



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 03 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Норвегийн Вант Улсад суугаа Онц багаад Бүрэн эрхт Элчин сайд Содовын Ононг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Норвегийн Вант Улсад суух Онц багаад Бүрэн эрхт Элчин сайдаар Балдангийн Энхмандахыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 374

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн даатгалын 2010 оны шимиgtгэлийн хэмжээг тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1, 8.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2010 онд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сар тутам төлөх эрүүл мэндийн даатгалын шимиgtгэлийн хувь, хэмжээг түүний хеделмэрийн хэлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь байхаар тогтоосугай.

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимиgtгэлийг хариуцдаг даатгууллагчийн сарын шимиgtгэлийн хэмжээг 670 төгрөгөөр, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч, малчин, ял здэлж байгаа хоригдол, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д зvasан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимиgtгэлийн хэмжээг 500 төгрөгөөр, гадвадын иргэн,

харьяалалгүй хүний сарын шимтгэлийн хэмжээг 4000 төгрөгөөр тус тус тогтоож, 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрүүл мэндийн даатгалын 2009 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 71 дүгээр тогтоолыг 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 377

Улаанбаатар
хот

**2010 оныг “Бизнесийн орчны
шинэтгэлийн жил” болгох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарласугай.

2. “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийнажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий зөвлөлийг хавсралт ёсоор баталсугай.

3. Бизнесийн орчинг сайжруулах талаар холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн төсөл боловсруулах, Засгийн газар болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан бизнесийн холбогдолтой дүрэм, журмыг цэгцлэх ажлыг хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

4. “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хурээнд эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, төрийн байгууллагуудаас хувийн хэвшил, иргэдэд үзүүлэх үйлчилгээг “нэг цонх”, “нэг цэг”-ийн зарчимд шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж,

биелгэлтийн явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд улирал тутам танилцуулж, нийтэд тогтолцож байхыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчуулунд уураг болгосугтай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.ХУРЭЛБААТАР

Засгийн газрын 2009 оны 377 дугаар
тогоолын хавсралт

**“БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛИЙН ЖИЛ”-ИЙН АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ
ЗЕВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: -Монгол Улсын Еренхий сайд С.Батболд

Орлогч дарга: -Монгол Улсын Төргүүн шадар сайд Н.Алтанкуяг

Гишүүд: -Сангийн сайд С.Баярцогт;

-Гадваад харилцааны сайд Г.Занданшатар;

-Зам, тэзвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай;

-Эрдэс баялаг, эрчим хүчиний сайд Д.Зоригт;

-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хурэлбаатар;

-Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж (зөвшилцсэнеөр);

-Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан (зөвшилцсэннэр);

-Еренхий сайдын зөвлөх С.Энхбаяр;

-Еренхий сайдын орон тооны бус зөвлөх Ч.Ганхуяг;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясталан;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Хурэлбаатар.

- Татварын еренхий газрын дарга Ц.Оюунбаатар;
- Гаалийн еренхий газрын дарга Д.Цэвээнжав;
- Мэдээлэл, шуудан, харилцав холбоо, технологийн газрын дарга Ж.Сансар;
- Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугар;
- Улсын буртгэлийн еренхий газрын дарга Л.Манхбаатар;
- Мэргэжлийн хяналтын ернхий газрын дарга Я.Содбаатар;
- Стандартчилал, хэмжүүл зүйн газрын дарга Г.Гантемер;
- Хөрөнгийн биржийн захирал Р.Содхүү;
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэл (тохиролцсоноор);
- Монголын ажил олгогч эздийн ногдсан холбооны еренхийлэгч Л.Нямсамбуу (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга: -Үндэсний хөгжил, шинэцгэлийн хорооны дарга Ч.Хашчулух

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
 хот

Иргэнд хишиг, хувь хуртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.1, 15.3, 17.4, Улсын Их Хурлын 2009 оны 85 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газравас ТОГТООХ нь:

1. "Хүний хөгжил сангас хөрөнгө зарцуулах журам"-ыг 1 дүгээр, "Монгол Улсын иргэн хишиг, хувь хуртэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталж, "Хүний хөгжил сан" дэвтрүйн загварыг 3 дугаар хавсралт ёсоор зөвшөөрсүгтэй.

2. Иргэний буртгалийн тухай хууль тогтоомжийн зорчилгүй иргэнд Хүний хөгжил сангас хишиг, хувь үе шаттай хуртэх ажлыг 2010 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн зохион байгуулахыг Нийгмийн хамгалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид давалгасугай.

3. 2010 онд иргэнд олгох хишиг, хувийг 2 хуваан олгож, үүнээс эхний эзлжинд 70.0 (далан) мянган төгрөгийг 2010 оны 2 дугаар сарын 1-ний өдрөнөс эхлэн олгоход шаардагдах хөрөнгийг тухай бүрт нь санхүүжүүлах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт даалгасутай.

4. Дараахь арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди наарт даалгасугай:

а) иргэний шинчилсэн бүртгэл явуулах үйл ажиллагааны нэмэлт зардалд 1,773.0 (нэг тэрбум долоон зуун далан түрвэн сая) сая төгрөг. Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны зардалд 236.0 (хоёр зуун гучин зургаан сая) сая төгрөгийг тус тус Засгийн газрын нөөц сангаас гаргаж, цавшид Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж баттуулах;

б) иргэн бүрт олгох "Хүний хөгжил сан" дэвтэр болон маягт хэвлүүлах зардалд зориулан 1,150.0 (нэг тэрбум нэг зуун тавин сая) сая төгрөгийг эргэн төлөгдөх нехцэлтэйгээр улсын төсвөөс санхүүжүүлж дэвтрийн үнийг иргэдээс хураан авч улсын төсвээг төвлөрүүлэх.

5. "Хүний хөгжил сан" дэвтрийн үнэ болон нийлүүлах хугацааг харгалзан дэвтэр, маягт хэвлэх ажлын гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид зөвшөөрсүгэй.

6. Улсын Их Хурлын 2009 оны 100 дугаар тогтоогд заасны дагуу иргэний шинчилсэн бүртгэлийг 2010 оны 10 дугаар сард багтаан явуулах зорилгоор шинчилсэн бүртгэл явуулах бэлтгэлийг хангах зөвлөх үйлчилгээ, программ хангамж, тоног төхөөрөмж нийлүүлах гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулахыг Улсын бүртгэлийн өрөнхий газрын дарга Л.Мөнхбаатарт зөвшөөрсүтэй.

7. Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан иргэний шинчилсэн бүртгэлийг 2010 онд явуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт, цавшид шинчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдийн талаар мэдээлэлд орсон өөрчлөлтийг сар бүр Хөдөлмөр, хalamжийн үйлчилгээний газарт хургуулж байхыг Улсын бүртгэлийн өрөнхий газрын дарга Л.Мөнхбаатарт, иргэний шинчилсэн бүртгэлд хамрагдсан иргэнд хишиг, хувийг 2010 онд багтаан хүртээж дуусгахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди наарт тус тус үүрэг болгосугай.

8. Иргэний шинчилсэн бүртгэлд Монгол Улсын иргэнийг

бүртгэх, Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хуртээх ажлыг зохион байгуулахад улсын бургал болон нийгмийн халамжийн байгууллагад бүх талын дэмжилгээ үзүүлж, бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлагатай хүний неец, херенгэ гарган ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга наарт даалгасугай.

9. Иргэний шиночилсон бургалд Монгол Улсын иргэнийг бүртгах, Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хуртээх ажлын дунг 2011 оны 2 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди наарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРОНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Т.ГАНДИ

Засгийн газрын 2010 оны 03 дугаар
тогтооплын 1 дүгээр хавсралт

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГААС ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүний хөгжил сангийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухайн жилийн төсвийн тухай хуулийн дагуу Хүний хөгжил сангаас хөрөнгө зарцуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмыар зохицуулна.

Хоёр. Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хуртээх санхүүжилтийн хуваарь

2.2. Хүний хөгжил сангийн тухайн жилийн төсвийн тухай хуулийн дагуу уг сангаас иргэнд хишиг, хувь хуртээхээр батлагдсан хөрөнгийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргваныг төв байгууллагын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**Гурав. Хүний хөгжил сангаас иргэнд
хишиг, хувь хуртээх**

3.1. Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хуртээх үйл ажиллагааг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргаваны байгууллага зохион байгуулна.

3.2. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргаваны байгууллага нь батлагдсан хуваарийн дунд багтаан тайлангийн өмнөх үеийн зарцуулалтын гүйцэтгэл, дансны үлдэгдэл, тухайн сар, улиралд гарах зарлагын урьдчилсан тооцоологд үндэслэн аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагад тухайн сар, улиралд иргэнд хишиг, хувь хуртээх зориулалтваар олгох санхүүжилтийн хуваарилалтыг хийж Сангийн яамны төрийн сангийн газарт ируулна.

3.3. Сангийн яамны төрийн сангийн газар нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ируулсан хүснэгтийг хянан үзээд Монголбанк дахь Хүний хөгжил сангийн данснаас аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хуртээх дансанд шилжүүлнэ.

3.4. Аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага нь иргэний сонголтыг үндэслэн дараах байдлаар иргэнд хишиг, хувь хуртээх үйл ажиллагааг арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэнэ:

3.4.1. иргэн бэлэн мөнгөвөр хишиг, хувь хуртэхээр сонголт хийсэн бол иргэн бүрийн хувийн дансанд зохих бичилт хийж мөнгийг бэлэнэр иргэнд олгоно;

3.4.2. иргэн бэлэн бусаар хишиг, хувь хуртэхээр сонголт хийсэн бол иргэн бүрийн хувийн дансанд зохих бичилт хийж үйлчилгээ үзүүлах байгууллагын дансанд төлбөрийг шилжүүлнэ;

3.4.3. арилжааны банкнаас энэ журмын 3.4.1, 3.4.2-т засны дагуу гүйлгээ хийх иргэний насрэйн жагсаалтыг аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага арилжааны банкинд цахим халбэрээр болон албан бичгээр хургуулна.

**Дөрөв. Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь
хуртээх санхүүжилтийн тайлан**

4.1. Арилжааны банк нь иргэнд хишиг, хувь хуртээсэн тухай тайланг дарва сарын 1-ний дотор аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

4.2. Төсвийн жилийн сар, улирал, жилийн эцэст нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Хүний хөгжил сангас иргэнд бэлэн болон бэлэн бусаар хишиг, хувь хүртээсэн талаархи ногдсон мэдээ, тайланг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу гаргана.

4.3. Аймаг дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын Хүний хөгжил сангийн дансны жилийн эцсийн үлдэгдлийг Монголбанк дахь Хүний хөгжил сангийн дансанд санхүүгийн жил бурийн эхний сард багтаан буцаан төвлөрүүлнэ.

Засгийн газрын 2010 оны 03 дугаар тогтооолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ХИШИГ, ХУВЬ ХҮРТЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл-

1.1. Монгол Улсын иргэн (цаашид "иргэн" гэх)-д Хүний хөгжил сангас хишиг, хувь хүртээхийн холбогдсон харилцааг энзхүү журмаар зохицуулна.

1.2. Иргэний шинчилсэн буртгэлд буртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй (хоёрдмоп харьяалалгүй) иргэн Хүний хөгжил сан (цаашид "сан" гэх)-гас хишиг, хувь хүртэнэ.

Хоёр. Иргэнийг шинчилсэн буртгэлд буртгах

2.1. Сангас хишиг, хувь хүртэх Монгол Улсын иргэнийг шинчилсэн буртгэлд буртгах ажлыг улсын буртгалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн буртгалийн халтэс, газар болон сум, хорооны буртгалийн ажилтан тус тус гүйцэтгэнэ.

2.2. Шинчилсэн буртгэлд хамрагдах иргэн нь Улсын буртгалийн өрөнхий хуулийн 5.3.1, 5.3.9, 5.3.11-5.3.13-т заасан дараахь төрлийн иргэний улсын буртгэлд шинчлэн буртгүүлнэ:

- терсний;
- иргэний үнэмлэхийн (дижитал зураг);
- биений давхцахгүй егегдлийн (гарын хурууны хээ);
- иргэний байнгын оршин суугаа газрын;
- шилжилт хөдөлгөөний.

2.3. Шинчилсэн буртгэлийг уг буртгэлд хамрагдах иргэнээс

холбогдох мэдээлэл (гарын хурууны хээ, дижитал зураг гэх мэт)-ийг хулзэн авснаас хойш 30 хоногийн дотор хийнэ.

2.4. Иргэний буртгэлийн тухай хууль тогтоомжийн зөрчилтэй иргэнийг шинчилсэн буртгэлд хамруулахгүй. Иргэн ут зөрчлөө улсын буртгэлийн байгууллагад хандан арилгуулах үүрэгтэй.

2.5. Шинчилсэн буртгэл явуулах журмыг улсын буртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

Гурав. Иргэний хишиг, хувь хүртэх хүснэгтийг хүлзэн авах, хянан шийдвэрлэх

3.1. Шинчилсэн буртгэлд хамрагдсан, иргэний үнэмлэх (терсний гарчилгээ) дээрх иргэний буртгэлийн код нь идэвхжсэн иргэн хишиг, хувь хүртэх хүснэгтийг сүм, хорооны нийгмийн ажилтан болон халамжийн асуудал хариуцсан мөргжилтэн (цаашид ажилтан гэх)-д гаргана.

3.2. Сүм, хорооны ажилтан нь иргэний үнэмлэх, терсний гарчилгээн дээр бичигдсэн регистрийн дугаар, иргэний буртгэлийн кодыг улсын буртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагасаа ируулсан иргэний буртгэлийн сангийн мэдээлэлтэй тулган шалгана. Буртгэлийн хууль тогтоомжийн зөрчилгүй иргэнд хишиг, хувь хүртэх "Хүний хөгжил сан" дэвтэр олгоно. Дэвтэрт хишиг, хувь авах иргэний овог, нэр, регистрийн дугаар, иргэний буртгэлийн код, хишиг, хувь авах хэлбэрийг бичнэ.

Иргэн нь хишиг, хувийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1.1, 17.1.2, 17.1.4-т зассан хэлбэрээр хүртэх хүснэгтийг гаргасан тохиолдолд үйлчилгээ үзүүлэх байгууллагын нэр, дансны дугаарыг дэвтэрт бичнэ.

3.3. Иргэний хишиг, хувийг тухайн иргэнд энэ журмын 3.2-т зассан дэвтэр өгсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор арилжааны банкаар дамжуулсан олгоно.

3.4. Иргэний буртгэлийн хууль тогтоомжийг зөрчсний улмаас улсын буртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын иргэний буртгэлийн мэдээллийн санд мэдээлэл нь ороогүй иргэний хишиг, хувь хүртэх хүснэгтийг уг зөрчлөө арилгасны дараа хүлээж авна.

3.5. 16-гаас доош насны хүүхдийн хишиг, хувийг эх (эцэг, асран хамгаалагч, харгалzan дэмжигч)-д олгоно.

Гэр булийн тухай хуулийн 63.1.4, 64.1.4, 64.1.5-д зассан иргэний

хишиг, хувийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно

3.6. Бүтэн ончин, эцэг эх, асран хамгаалагч нь тогтоогдоогүй зэрэг шалтгаанваар асрамжийн газарт болон нийгмийн халамжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу ерх, иргэний асрамжид байгаа, эсхүл оршин суух тодорхой хаягтүү (тэнэмэл амьдралтай) 16 хүртэлх насын хуухдэд хүртээх хишиг, хувийг тухайн хуухдийн нар дээр хадгаламж нээж бансанд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрүүг тухайн хуухдийг асарч байгаа асрамжийн газар болон аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага хадгалж, хуухдийг 16 наасанд хүрч, иргэний үнэмлэх авсны дараа еөрт нь хүлээлгэн өгнө.

3.7. Гадаадад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд хүртээх хишиг, хувийг тухайн иргэний гаргасан хүснэгт, итгэмжлэл, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөвлөгөөний газрын тодорхойлолтыг үндэслэн итгэмжлэгдсэн этгээдэд нь олгоно. Хэрэв тухайн иргэн итгэмжлэл гаргавгүй бол түүнд хүртээх хишиг, хувь дараагийн жилд хадгалагдан үлдэнэ.

3.8. Монгол Улсын иргэн тус улсын харьяатаас гарч гадаад улсын харьят болсон тохиолдолд сүүлийн жилд түүнд олгох хишиг, хувийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж олгоно. Монгол Улсын харьят болсон иргэнд хишиг, хувийг дараагийн жилээс нь эхлэн олгоно.

3.9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллагад ял здэлж байгаа болон цагдан хоригдож байгаа этгээдийг иргэний шинчилсэн бүртгэлд хамруулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын санхүүгээр дамжуулан хишиг, хувийг тухайн этгээдийн нарийн дансанд нь шилжүүлнэ.

Дөрөв. Хишиг, хувь хүртэх хугацаа

4.1. Монгол Улсын иргэнд хишиг хувийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу Улсын Их Хурлаас тухайн жилд тогтоосон хэмжээгээр олгоно.

4.2. Иргэнд хишиг, хувийг урьдчилж олгохгүй.

Тав. Хишиг, хувь хүртэхэд бурдуулах бичиг баримт

5.1. Хишиг, хувь хүртэх иргэн дараахь бичиг баримтыг бурдуулна:

5.1.1. иргэний үнэмлэх;

5.1.2 16-гас доош насын хуухдийн хувьд төрсний гэрчилгээ, эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн иргэний

үнэмлэх;

5.1.3. хэрэв хуухэд асрамжийн газарт байгаа бол тухайн асрамжийн газрын тодорхойлолт;

5.1.4. Гэр бүлийн тухай хуулийн 66.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон бол сүм, дуургийн Засаг даргын шийдвэр, түүний хуулбар;

5.1.5. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 16.2-т заасан иргэний хишиг, хувийг авах бол нас барсны гэрчилгээ, түүний хуулбар;

5.1.6. гадваадад амьдарч байгаа Монгол Улсын иргэний хувьд Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөвлөгчийн газрын тодорхойлолт, итгэмжлэл.

Зургаа. Бусад

6.1. Хишиг, хувь хүртэх асуудлаар сүм, хорооны ажилтны тавьсан шаардлагыг хулээн зөвшөөрөөгүй тохиолдолд иргэн гомдлоо сүм, хорооны Засаг дарга, аймаг, дуургийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагад гаргаж болно. Гомдлыг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэн. Иргэн сүм, хорооны Засаг дарга болон аймаг, дуургийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын шийдвэрийг хулээн зөвшөөрөөгүй тохиолдолд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар маргванаа шийдвэрлүүлнэ.

6.2. Хишиг, хувь хүртэж байгаа иргэн шилжихэд улсын буртгэлийн байгууллага оршин суугаа хаягийн веерчлэлтийг хийж, тухайн орон нутгийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага шилжих хүртэлх хугацаанд уг иргэний хүртсэн хишиг, хувийн хэмжээний талаар тодорхойлолтыг олгоно.

6.3. Энэхүү журмын 6.2-т заасан тодорхойлолтыг үндэслэн иргэнд шилжин ирсн газрын нийгмийн халамж үйлчилгээний байгууллага хишиг, хувийг үргэлжлүүлэн олгоно.

6.4. Энэхүү журмын бдахь хэсэгт заасан бичиг баримтыг хуурамчаар үйлдэж хишиг, хувь хүртэх нэхцэл бурдуулсан албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, мөнгийг гэм буруутай этгээдээр нэхэн төлүүлнэ.

6.5. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 16.1-д заасан тохиолдолд сүм, хорооны ажилтан нь тухайн иргэний хишиг, хувь хүртэх эрх дуусгавар болсон тухай "Хүний хөгжил сан" дэвтэрт тэмдэглэл хийнэ.

Засгийн газрын 2010 оны 03 дугаар
тогтоолын З дугаар хавсралт

"ХҮНИЙ ХӨГЖИЛ САН" ДЭВТРИЙН ЗАГВАР

Хавтас

СОЁМБО

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНИЙ ХӨГЖИЛ САН

Хавтасны ард

Бид хамтдаа чадна

1 дүгээр хуудас

Дугаар _____

Зураг

_____ аймаг, дүүргийн/_____

сум, хорооны иргэн _____ -ний

-нд олгов.

_____ аймаг, дүүргийн нийгмийн халамж

үйлчилгээний байгууллагын дарга _____ / /

тамга

..... оны сарын -ны өдөр

2 дугаар хуудас

1	Үргийн овог	
2	Эцэг/эх/-ийн нэр	
3	Нэр	
4	Хүйс Эр Эм	
5	Иргэний үнэмлэхийн дугаар	
	Төрсний гэрчилгээний дугаар	
6	Регистрийн дугаар	
7	Иргэний бүртгэлийн код	
8	Оршин суугаа хаяг	
16 хүртэлх насны хуухдийн эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн мэдээлэл		9 Овог
		10 Нэр
		11 Иргэний үнэмлэхийн дугаар
		12 Регистрийн дугаар

3 дугаар хуудас

4, 6, 8 дугаар хуудас

ХИШИГ, ХУВЬ ОЛГОЛТ

д/д	Хишиг, хувь олгосон хэлбэр			
	Бэлэн монгөөр	Тэтгэврийн болон эрүүл мэндийн двдтгальян шимтгэлийн тэлберт	Эруул мэнд, оловсролын үйлчилгээний тэлберт	Орон сууц худалдан авсны тэлберт

1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
11				
12				

5, 7, 9 дүгээр хуудас

Олгосон он сар	Дансны дугаар	Гарын үсэг (тэмдэг)

10, 11 дүгээр хуудас

ХИШИГ, ХУВЬ ХҮРТЭГЧИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ

д/д	Шилжүүж явсан			Шилжин ирсан		
	Аймаг, дүүргэг, сум, хороо	Он, сар, өдөр	Гарын үсэг (тэмдэг)	Аймаг, дүүргэг, сум, хороо	Он, сар, өдөр	Гарын үсэг (тэмдэг)
1						
2						
3						
4						
5						
6						

12 дугаар хуудас

ТЭМДЭГЛЭЛ

Төгсгөлийн хуудас

САНАМЖ

1. Хишиг, хувь авах бүртээ иргэний үнэмлэх болон энэхүү дэвтрүүг заавал авч ирнэ.

2. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зассанчлан хишиг, хувив дараах хэлбэрээр авч болно:

- балзан менгв;
- тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн телбер;
- орон сууц худалдаж авсны телбер;
- эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний телбер.

3. Дэвтрүүг хаяж үрэгдуулблэл 7 хоногийн дотор харьяалах нутаг дэвсгэрийнхээ нийгмийн халамж үйлчилгээний байгууллагад мэдэгдэж хүчингүй болгуулна.

4. Хуурамчаар баримт бичиг үйлдэж хишиг, хувь хуртах нехцел бүрдүүлсэн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5. Хишиг, хувийг тогтоосон хугацаанд олгох багеөд урьдчилан олгохгүй.

6. Шилжиж ирсэн газарт бүртгүүлж, шилжилт хөдөлгөөн хийгдсэн одреес эхлэн хишиг, хувь хуртээнэ.

Дэвтэр эзэмшигчийн гарын үсэг

/

/

Хаяг:

“Төрийн мэдүүлэл” эмхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-майл: tariin_medeeli@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1

Индекс: 14803